

## CLT - Central Location Test



Зорилтот хэрэглэгчдийг судалгаанд хамруулахын тулд хүн ихтэй байдаг газруудад, томоохон худалдааны төвүүд, үйлчилгээний газарт судалгааны нэгж байгуулан, тухайн газраар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийг судалгаанд урьж оролцуулдаг судалгааны мэдээлэл цуглуулалтын нэг арга юм.

Уг судалгааны аргын давуу тал нь судалгааны түүвэрлэлтийг хийхдээ зорилтот хэрэглэгчдийг ихээр цуглах газрыг сонгодог бөгөөд зорилтот хэрэглэгчдийн төлөөллийг судалгаанд өргөнөөр хамруулах боломж олгодог. Ингэснээр цаг хугацааг хэмнэхээс гадна судалгаанд оролцогчдыг хайж олох бус, нэг дор цугласан иргэдээс судалгааны шалгуурт тэнцэх, зорилтот бүлгийн, үнэн зөв мэдээлэл өгөх хүнийг судалгаанд оролцуулах боломжийг олгодог юм.